



Хүчин төгөлдөр хэрэгжсэн өдөр:
2024 оны 6-р сарын 2

KT&G

ЁС ЗҮЙН ДҮРЭМ



Korea Ginseng Corp.



Yungjin Pharm



Tae-a Industry



KGC Life & Gin



KGC Yebon



SangSang Stay

COSMOCOS

CEO мэндчилгээ

Ёс зүйн дүрмийн танилцуулга

Ёс зүйн дүрмийн тодорхойлолт
Ёс зүйн дүрмийн хэрэгцээ
Ёс зүйн дүрмийн хэрэгжүүлэлт
Ёс зүйгүй үйлдлийг мэдэгдэх тогтолцоо
Удирдлагын мөрдөх журам

Жишиг компани

1 Ажлын ёс зүй

- 1.1 Ашиг сонирхлын зөрчил
- 1.2 Дотоодын мэдээллийн худалдааг хориглох
- 1.3 Авлига, хээл хахуулиас урьдчилан сэргийлэх
- 1.4 Улс төрийн үйл ажиллагаа
- 1.5 Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл ашиглах
- 1.6 Шударга, хууль ёсны дагуу ажил гүйцэтгэх

2 Хөрөнгө, мэдээллийн хамгаалалт

- 2.1 Хөрөнгө хамгаалах
- 2.2 Мэдээлэл хамгаалах
- 2.3 Хувийн мэдээлэл хамгаалах

3 Компанийн баримт бичиг, бүртгэл

- 3.1 Бүртгэлийг үнэн зөв хөтлөх, нягтлан бодох бүртгэлийн стандартыг дагаж мөрдөх
- 3.2 Ил тод болгох зарчмыг дагаж мөрдөх
- 3.3 Баримт бичиг хадгалах

Дэвшилтэт компани

4 Дотоодын болон олон улсын худалдаа

- 4.1 Шударга худалдаа
- 4.2 Нийлүүлэлтийн сүлжээний бодлого
- 4.3 Олон улсын худалдааны дүрэм журмыг дагаж мөрдөх
- 4.4 Мөнгө угаах, татвараас зайлсхийхээс урьдчилан сэргийлэх

5 Борлуулалт ба маркетинг

- 5.1 Хариуцлагатай борлуулалт болон маркетингийн үйл ажиллагаа
- 5.2 Ил тод байдал
- 5.3 Дүрэм журмыг дагаж мөрдөх

6 Судалгааны ёс зүй

- 6.1 Хариуцлагатай судалгаа хөгжүүлэлтийн үйл ажиллагаа
- 6.2 Судалгааны бүрэн бүтэн байдал
- 6.3 Амьтан хамгаалах

Хүртээмжтэй компани

7 Нийгмийн өмнө хүлээсэн үүрэг

- 7.1 Байгаль орчныг хамгаалах
- 7.2 Нийгмийн хувь нэмэр
- 7.3 Үйлчлүүлэгчдэд төвлөрсөн байдал
- 7.4 Хувьцаа эзэмшигчдийг хүндэтгэх

8 Хүний эрхийн удирдах зарчим

- 8.1 Хүний эрхийг хамгаалах бодлогыг дагаж мөрдөх
- 8.2 Ажлын байрны дарамт, бэлгийн дарамт үзүүлэхийг хориглох
- 8.3 Ялгаварлан гадуурхахыг хориглох болон ялгаатай байдлыг хүндэтгэх
- 8.4 Аюулгүй ажлын орчныг бүрдүүлэх
- 8.5 Хөдөлмөрийн суурь эрхийг хангах

CEO мэндчилгээ

Бид дэлхий нийтийн бизнесийн орчны өөрчлөлт дунд үндсэн өрсөлдөх чадвар болон глобал мэргэжлийн чадварт суурилсан шинэ байгууллагын бүтцийг бий болгож гүйцэтгэлийн чанарыг сайжруулах замаар KT&G группийг Global Top-tier шилдэг компани болгох нэгдсэн нэг зорилготой билээ.

Ёс зүйн дүрэм нь бидний зорилго, алсын харааг хэрэгжүүлэх явцад тулгарах олон бэрхшээл, эрсдэл, тодорхойгүй байдлын үед зөв шийдвэр гаргах стандартыг харуулж өгдөг удирдамж юм. Өдөр тутмын ажил, шийдвэр гаргах үйл явцад ёс зүйн үнэлэмжийг эрхэмлэн, ёс зүйн дүрэмд заасан зарчмын дагуу ажилласнаар бид хэрэглэгч, хувьцаа эзэмшигч, оролцогч талууд болон нийгмийн итгэлцэл дээр тулгуурлан KT&G группийн тогтвортой өсөлтийг бий болгох боломжтой болох юм.

Ёс зүйн дүрэм дээр үндэслэн KT&G группийг дэлхийн тавцанд амжилттай гаргахын төлөө хамтдаа зүтгэцгээе. Баярлалаа.

KT&G ТУЗ-ийн дарга,
Ерөнхийлөгч
Бан Гён Ман
2024 он 6 сар

Bang Kyung-man

Ёс зүйн дүрмийн танилцуулга

Ёс зүйн дүрмийн тодорхойлолт

Энэхүү ёс зүйн дүрэм нь KT&G-н удирдлагын үнэт зүйлс болох “жишиг, дэвшилтэт, хүртээмжтэй компани.болгохын төлөө дагаж мөрдөх үйл ажиллагааны зарчим юм.

Ёс зүйн дүрмийн хэрэгцээ

Энэхүү ёс зүйн дүрэм нь бизнесийн шийдвэр гаргах үед мөн үйлчлүүлэгч, хувьцаа эзэмшигч, өрсөлдөгч, хамтрагч зэрэг бусад оролцогч талуудтай, түүнчлэн улс орон, олон нийттэй харилцахдаа хэрхэн ёс зүйн дагуу, хууль ёсны дагуу харилцах талаарх стандартыг бий болгох зорилгоор энэхүү дүрмийг тогтоосон юм.

Бид энэхүү ёс зүйн дүрмийг ойлгож, дагаж мөрдсөнөөр ёс суртахууны менежментийг баримталж, нийгмийн хариуцлагаа биелүүлж, өөрчлөлт, шинэчлэлтийг эрэлхийлдэг глобал компани болох KT&G группийн тогтвортой хөгжлийг эрхэмлэж, хууль эрх зүй болон нийгмийн эрсдэлээс бид өөрсдийгөө болон компаниа хамгаалж чадна.

Ёс зүйн дүрмийн хэрэгжүүлэлт

Тус ёс зүйн дүрэм нь KT&G групп болон KT&G группийн дотоодын болон гадаадын охин компани(цаашид “KT&G” эсвэл “компани” гэх)-д ажиллаж байгаа бүх ажилтан, албан тушаалтнуудад адил тэгш үйлчлэх зорилготой юм. Нэмж дурдахад KT&G групп нь хамтарсан компани, түнш зэрэг оролцогч талууд ч гэсэн тухайн ёс зүйн дүрмийг хүлээн зөвшөөрч, дагаж мөрдөхийг уриалдаг.

Энэхүү ёс зүйн дүрэмд заасан стандарт нь тодорхой нэг улс, харьяа нутаг дэвсгэрийн хууль тогтоомж, ёс заншилтай зөрчилдөх тохиолдолд тухайн орон нутгийн хууль тогтоомж, ёс заншил нь энэхүү ёс зүйн дүрэмд зааснаас илүү хатуу стандарттай бол илүү хатуу стандарттай тухайн орон нутгийн хууль тогтоомж, ёс заншлыг нэн тэргүүнд тавина. Эсрэгээр энэхүү ёс зүйн дүрэм нь тухайн орон нутгийн хууль тогтоомж, ёс заншлас илүү хатуу стандарттай бол энэхүү ёс зүйн дүрэм нь зөвхөн холбогдох хууль тогтоомж, ёс заншилд нийцсэн хэмжээнд л хамаарна.

Энэхүү ёс зүйн дүрэм нь ажил гүйцэтгэх явцад гарч болох бүх нөхцөл байдалд хамаарахгүй. Тиймээс KT&G групп нь тус ёс зүйн дүрмээс гадна өөр журам, удирдамж, бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх боломжтой. Мөн бид энэхүү ёс зүйн дүрэм, холбогдох компанийн дүрэм журамд заагаагүй өөр ямар нэгэн асуудал, ёс зүйн зөрчилтэй тулгарвал харьяа хэлтсийн дарга эсвэл харьяа компанийн ёс зүйн удирдлагын хэлтэстэй зөвлөлдөж ёс зүйн зөв шийдэлд хүрэхэд анхаарах хэрэгтэй.

Ёс зүйн дүрмийг дагаж мөрдөөгүй ажилтан, албан тушаалтнуудад холбогдох дүрэм журмын дагуу сахилгын арга хэмжээ ногдуулж болно.

Ёс зүйгүй үйлдлийг мэдэгдэх тогтолцоо

Ёс зүйн дүрмийг зөрчсөн эсвэл ёс зүйгүй, хууль бус үйлдлийг мэдсэн тохиолдолд мөн тийм нөхцөл байдал бий болсон хэмээн сэжиглэж байгаа тохиолдолд нэн даруй тухайн асуудлыг компанийн холбогдох ёс зүйгүй үйлдлийг мэдээлэх сувгаар дамжуулан эсвэл KT&G группийн төлөөлөл болсон ёс зүйгүй үйлдлийг мэдээлэх сувагт(www.ktng.com → Ёс зүйгүй үйлдлийг мэдэгдэх) мэдэгдэхийг хүсэж байна.

Та бүхэн зориг гаргавал, KT&G групп нь таныг сонсож, идэвхтэй дэмжих болно. KT&G групп нь мэдээлсэн агуулгыг шударгаар, бодитоор судалж, судалж байх явцад мэдээлсэн хүний хувийн мэдээллийг чандлан хамгаалах болно.

KT&G групп нь ёс зүйгүй үйлдлийг мэдээлсэнтэй холбоотой ямар нэгэн хариу арга хэмжээ авах, таагүй хандлага гаргахыг хүлээн зөвшөөрдөггүй бөгөөд ийм үйлдэл нь тус ёс зүйн дүрмийг шууд зөрчсөн гэж үзэх болно. KT&G групп нь дээрх хариу арга хэмжээ авах, таагүй хандлага гаргах тал дээр хатуу бодлого баримталдаг гэдгийг дахин онцолмоор байна.

Удирдлагын мөрдөх журам

KT&G группийн удирдах зөвлөл зэрэг бүх удирдлагууд нь ажилтан, албан тушаалтнуудын ажлын орчин болон компанийн соёлд чухал нөлөө үзүүлэх боломжтой. Тиймээс удирдлагууд нь ажилтнуудад тус ёс зүйн дүрмийг дагаж мөрд хэмээн шаардах нь хангалтгүй бөгөөд өөрөө энэхүү ёс зүйн дүрмийг бүрэн ойлгож, дагаж мөрдөн үлгэр дуурайл үзүүлэх ёстой.

Удирдлагууд нь энэхүү ёс зүйн дүрмийг бүх ажилтнууд тууштай дагаж мөрдөхөд анхаарч ажиллан ёс зүйн дүрэмтэй холбогдуулан чөлөөтэй асууж, ёс зүйн дүрмийг хэрэгжүүлээгүй болон зөрчил гарах магадлалтай үйлдлийг илрүүлсэн тохиолдолд үүнийг мэдээлэх орчныг бүрдүүлэх хэрэгтэй.

Ёс зүйгүй үйлдэлтэй холбоотой мэдээлэл бүртгэгдсэн тохиолдолд удирдлага нь үүнийг харьяа компанийн ёс зүйн удирдлагын хэлтэст мэдээлж, мэдээлэгчид хариу арга хэмжээ авахаас урьдчилан сэргийлэх үүднээс хянаж, мэдээлэгчийг хамгаалахад анхаарч ажиллах ёстой.

Ялангуяа, удирдлага нь ёс зүйгүй үйлдлийг мэдэгдэх нь КТ&Г группийн гишүүний үүргээ биелүүлж байгаа гэдгийг санаж, мэдээлэгчийн эсрэг хариу арга хэмжээ авах талаар санаа зовоож буй бүхий л нөхцөлийг арилгах хэрэгтэй гэдгийг мөн санаж байх ёстой.



1
Ажлын ёс зүй

2
Хөрөнгө, мэдээллийн
хамгаалалт

3
Компанийн тайлан,
бүртгэл

Жишиг

компани

1 Ажлын ёс зүй

- 1.1 Ашиг сонирхлын зөрчил
- 1.2 Дотоод мэдээллийн худалдааг хориглох
- 1.3 Авлига, хээл хахуулиас урьдчилан сэргийлэх
- 1.4 Улс төрийн үйл ажиллагаа
- 1.5 Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл ашиглах
- 1.6 Шударга, хууль ёсны дагуу ажил гүйцэтгэх

2 Хөрөнгө, мэдээллийн хамгаалалт

- 2.1 Хөрөнгө хамгаалах
- 2.2 Мэдээлэл хамгаалах
- 2.3 Хувийн мэдээлэл хамгаалах

3 Компанийн тайлан, бүртгэл

- 3.1 Бүртгэлийг үнэн зөв хөтлөх, нягтлан бодох
бүртгэлийн стандартыг дагаж мөрдөх
- 3.2 Ил тод болгох зарчмыг дагаж мөрдөх
- 3.3 Баримт бичиг хадгалах



1

Ажлын ёс зүй

1.1 Ашиг сонирхлын зөрчил

KT&G групп нь ажилтан, албан тушаалтнуудын хувийн ашиг сонирхол болон байгууллагын ашиг сонирхол хооронд үүссэн болон үүсэж болзошгүй бүхий л ашиг сонирхлын зөрчилд анхааран ажилладаг. KT&G группийн албан тушаалтнууд болон ажилчид ашиг сонирхлын зөрчил гарсан тохиолдолд үргэлж компанийн хувьд хамгийн сайн сонголт нь юу болохыг анхаарч шийдвэр гаргах хэрэгтэй.

1.1.1 Ашиг сонирхлын зөрчил илрэх магадлалыг ил болгох

KT&G ажилтан, албан тушаалтнууд нь оролцогч талууд зөрчилдөх, зөрчил үүсэж болзошгүйг мэдсэн бол энэ тухайгаа хэлтсийн даргадаа нэн даруй мэдэгдэх эсвэл ёс зүйн удирдлагын хэлтэст мэдэгдэх ёстой. Хэлтсийн дарга, ёс зүйн удирдлагын асуудал эрхэлсэн хэлтсийн дарга нь

ажилтан, албан тушаалтнууд холбогдох нөхцөл байдлын талаар мэдээлэх үед ашиг сонирхлын зөрчил үүсэх магадлалыг шалгаж, хэрэв магадлал өндөр байгаа нь батлагдсан тохиолдолд тухайн ажилтан, албан тушаалтны ажил үүрэг, хариуцлагыг өөрчлөх зэрэг шаардлагатай арга хэмжээг авах буюу шаардах хэрэгтэй.

Ашиг сонирхлын зөрчил нь ажилтны гэр бүл, хамаатан садан, танил тал хоорондын харилцаа төдийгүй ажилтан өмнө нь ажиллаж байсан ажлын байртай холбогдох харилцаа зэрэг төрөл бүрийн салбарт илрэх боломжтой тул үргэлж анхаарал болгоомжтой байх хэрэгтэй.

Example

• Ашиг сонирхлын зөрчил үүсэх магадлал өндөр байгаа тохиолдолд

- Ажилтны гэр бүл, хамаатан садан, танил талыг ажилд авах тохиолдолд
- Ажилтны гэр бүл, хамаатан садан, танил тал нь KT&G группийн бизнест оролцох тохиолдолд
- Ажилтны гэр бүл, хамаатан садан, танил тал нь ажиллаж буй эдийн засгийн томоохон ашиг сонирхол бүхий компани, нэгдлийг KT&G группийн бизнест оролцуулах тохиолдолд
- Ажилтны ажиллаж байсан компани, нэгдэл эсвэл тэр байгууллагын төлөөлөгч нь KT&G группийн бизнест оролцох тохиолдолд

Example

• Эдийн засгийн ашиг сонирхол үүсэж болох тохиолдол

- KT&G группийн өрсөлдөгч, бизнесийн түнш болон үйлчлүүлэгчийн худалдаанд оролцонгоо тухайн өрсөлдөгч, бизнесийн түнш болон үйлчлүүлэгчтэй эдийн засгийн томоохон ашиг сонирхлыг бий болгосон үйлдэл
- Өрсөлдөгч, бизнесийн түнш, болон үйлчлүүлэгчтэй ижил хуулийн этгээдэд хөрөнгө оруулсан эсвэл хамтарсан компанийг байгуулсан үйлдэл
- Өрсөлдөгч, бизнесийн түнш, үйлчлүүлэгч болон хамт ажилладаг ажилтнаас мөнгө зээлсэн, эсвэл зээлүүлсэн үйлдэл
- Бусад KT&G группийн ашиг сонирхлын эсрэг эдийн засгийн үйл ажиллагаа

1.1.2 Эдийн засгийн ашиг сонирхлоос зайлсхийх

KT&G группийн ажилтан, албан тушаалтан нь өрсөлдөгч, бизнесийн түнш, үйлчлүүлэгч, болон өөр ажилтантай эдийн засгийн ашиг сонирхлын зөрчил гарахаас болгоомжлох ёстой.

1.1.3 Ажлаас бусад үйл ажиллагаа

KT&G группийн ажилтан, албан тушаалтан нь KT&G группээс хүлээн авсан ажил үүргээ үнэнчээр гүйцэтгэх үүрэгтэй. Иймд KT&G группийн ажилтан, албан тушаалтан нь ажил үүргээсээ өөр ашиг хонжоо хайсан ажил эрхэлж болохгүй.

1.2 Дотоод мэдээллийн худалдааг хориглох

KT&G групп нь олон нийтэд мэдэгдээгүй KT&G, бизнесийн түнш, үйлчлүүлэгчийн дотоодын мэдээллийг хатуу чанд хамгаалдаг. KT&G группийн ажилтан, албан тушаалтан нь дотоодын мэдээллийг ашиглан KT&G групп болон бизнесийн түншийн хувьцаа, хөрвөх бонд зэргийг худалдаалахыг хориглоно. Мөн дээрх үйлдлийг хийх зорилгоор бусдад дотоодын мэдээллийг дамжуулахыг хориглоно.

※ “Дотоодын мэдээлэл” нь бусдад ил бус байдаг мэдээлэл буюу хөрөнгө оруулалттай холбоотой шийдвэр гаргахад үндэслэн ашигладаг бөгөөд бизнесийн үзүүлэлт, өөрийн хувьцааг эзэмших, хөрөнгийн нэмэгдэл зэрэг санхүүгийн бүтцэд гарсан өөрчлөлт, их хэмжээний хөрөнгө оруулалт, компани нэгдэх болон худалдан авах, шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэх болон гаргах, шинэ бизнесийн түнштэй гэрээ байгуулах зэрэг холбогдох мэдээллийг агуулдаг.

Example

• Дотоод мэдээллийн худалдааг тодорхойлох тохиолдлууд

- Бизнесст хамааралгүй ажилтан, албан тушаалтанд дотоодын мэдээллийг ил болгох үйлдэл
- Үйлчлүүлэгч, бизнесийн түнш, гэр бүл болон танил гэх мэт гуравдагч этгээдэд дотоодын мэдээллийг ил болгох үйлдэл
- Дотоодын мэдээллийг мэдэж байгаа үед тухайн мэдээллийг ашиглан хувьцааг худалдах үйлдэл
- Дотоодын мэдээллийг мэдэж байгаа үед гуравдагч этгээдэд хувьцааг арилжаалахыг санал болгох үйлдэл

1.3 Авлига, хээл хахуулиас урьдчилан сэргийлэх

KT&G групп нь хээл хахууль, авлигатай холбоотой үйл ажиллагааг хатуу хориглодог бөгөөд улс бүрийн холбогдох хууль тогтоомжийг дагаж мөрддөг.

1.3.1 Авлига, хээл хахууль өгөхийг хориглоно.

KT&G группийн ажилтан, албан тушаалтнууд төрийн байгууллагын төрийн албан хаагч, төрийн байгууллага, нийтийн байгууллага, олон улсын байгууллагын ажилтан, албан тушаалтан болон бусад компанийн бизнестэй холбоотой хувийн хэвшлийн хувь хүн, байгууллагад шууд болон гуравдагч этгээдээр дамжуулан хээл хахууль, зохисгүй эд хөрөнгийг өгөх, өгөхөөр амлах, санал болгохыг хориглоно. Мөн холбогдох этгээдээс хээл хахууль, зохисгүй эд хөрөнгө авах, шаардахыг хориглоно.

1.3.2 Хууль бус хүсэлт тавихыг хориглоно.

KT&G группийн ажилтан, албан тушаалтан нь бизнесийн ашиг, хонжоо олохын тулд шууд болон гуравдагч этгээдээр дамжуулан хууль бус хүсэлт тавихыг хориглоно. Мөн холбогдох этгээдүүдээс хууль бус хүсэлтийг хүлээн авч тухайн ажлыг гүйцэтгэхийг хориглоно.

1.3.3 Бэлэг болон хүлээн авалт хийх

Бизнесийн орчны хэвийн хэмжээнээс хэтэрч шударгаар ажил үүргээ гүйцэтгэхэд нөлөө үзүүлж болохуйц бэлэг өгөх болон хүлээн авалт хийх нь авлига, хээл хахуулийн үйлдэл гэж үзэж болох тул анхаарал болгоомжтой байх хэрэгтэй. Ажлын хувьд эрүүл харилцааг бий болгох, хадгалахын төлөө бэлэг өгөх, хүлээн авалт хийх талаар улс орон бүрийн хууль тогтоомж, соёл, ёс заншил өөр байдаг боловч ямар ч тохиолдолд үүнийг хууль ёсны дагуу, зүй зохистой хэрэгжүүлэх хэрэгтэй.

Example

• Авлига гэж үзэж болох бэлэг, хүлээн авалтын жишээ

- Хээл хахуульд бэлэн мөнгө, компанийн бүтээгдэхүүн, согтууруулах ундаа, гольф зэрэг хүлээн авалт болон цайллагын үйлдэл, унаа, буудал зэргээр хангах зэрэг эд хөрөнгийн ямарваа нэгэн ашиг сонирхол багтах бөгөөд үүгээр хязгаарлагдахгүй.
- Төрийн албан тушаалтнуудад энгийн журам, үйлчилгээг хурдан авахын тулд төлж буй төлбөр(жишээ нь: гарын мөнгө) эсвэл бага хэмжээний бэлэг нь ихэнх улс оронд авлига гэж тооцогддог.

1.4 Улс төрийн үйл ажиллагаа

KT&G групп нь ажилтан, албан тушаалтнуудын улс төрийн үйл ажиллагаанд оролцох, тэр дундаа улс төрийн үзэл бодлоо илэрхийлэх, санал өгөх эрхийг хүндэтгэдэг. Гэхдээ улс төрийн үйл ажиллагаанд оролцохын өмнө дараах зүйлсийг анхаарах хэрэгтэй.

- Улс төрийн үйл ажиллагаанд оролцохдоо KT&G группийг төлөөлөөгүй болохоо, компани бус өөрийн хувийн үзэл бодол гэдгийг тодотгох ёстой.
- KT&G группийг төлөөлж улс төрийн хандив өгөхгүй.
- Ажлын байраа улс төрийн үйл ажиллагааны талбар болгохгүй.
- Улс төрийн үйл ажиллагаанаас болж өөрийн ажил үүргээ үнэнчээр биелүүлэхгүй байх, эсвэл тухайн үйл ажиллагаа нь ажлын байран дээрх өөрийн үүрэг хариуцлагатай зөрчилдөхгүй байхад анхаарах ёстой.
- KT&G группийн ажилтан, албан тушаалтан нь ажлын цагаар урьдчилан зөвшөөрөл авалгүйгээр улс төрийн үйл ажиллагааг явуулж болохгүй.

1.5 Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл ашиглах

KT&G групп нь ажилтан, албан тушаалтны үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хүндэтгэдэг. Гэхдээ олон нийтийн мэдээллийн хэрэгсэл нь хувийн болон бизнесийн салбарын зааг тодорхойгүй байдаг төдийгүй мэдээллийн тархалт өндөр байдаг тул, KT&G группийн ажилтан, албан тушаалтан нь олон нийтийн мэдээллийн хэрэгсэл ашигласны улмаас хувь хүн болон компанид сөрөг нөлөөлөл үзүүлэхээс зайлсхийхийн тулд дараах зүйлсийг онцгой анхаарах ёстой.

- Нийгмийн маргаан үүсгэж болзошгүй санал бодлоо илэрхийлэхдээ KT&G группийг төлөөлөөгүй хувийн үзэл бодол гэдгээ тодотгох ёстой.
- Ажилтай холбоотой мэдээлэл задрахаас урьдчилан сэргийлэхэд анхаарах хэрэгтэй.
- Өөр хүний зураг, видеог байршуулахдаа эзнээс нь зөвшөөрөл авах ёстой.
- Өөр хүний нэр төрд халдах, зохиогчийн эрхийг зөрчих зэрэг хууль бус контент байршуулж болохгүй.
- Ажлын гүйцэтгэлийг бууруулж болох тул олон нийтийн хэрэгслийг хэт их ашиглахаас татгалзах хэрэгтэй.

1.6 Шударга, хууль ёсны дагуу ажил гүйцэтгэх

KT&G группийн ажилтан, албан тушаалтан нь ажил үүргээ гүйцэтгэж байх үед холбогдох хууль тогтоомж болон KT&G группийн дотоодын дүрэм, журмын дагуу ажлаа ил тод гүйцэтгэх ёстой. Мөн KT&G группд сөрөг нөлөө үзүүлэх боломжтой аливаа үйл ажиллагаанд оролцохыг хориглоно. KT&G группийн ажилтан, албан тушаалтан нь хууль бус үйлдэл, ёс зүйн зөрчлийн талаар мэдсэн эсвэл тийм үйлдэл хийх үүрэг даалгавар авсан тохиолдолд нэн даруй харьяа хэлтэс эсвэл ёс зүйн удирдлагын асуудал эрхэлсэн хэлтэс рүү мэдэгдэх хэрэгтэй.

2

Хөрөнгө, мэдээллийн хамгаалалт

2.1 Хөрөнгө хамгаалах

KT&G группийн бүх хөрөнгө нь компани болон хувьцаа эзэмшигчдийн хөрөнгө бөгөөд компанийн тогтвортой өсөлт хөгжилд заавал шаардлагатай хүчин зүйл тул үр ашигтайгаар ашиглах хэрэгтэй ба хууль бусаар ашиглах, хулгайлах болон бусад аливаа төрлийн зүй бус хэрэглээнээс хамгаалагдах ёстой.

KT&G группийн ажилтан, албан тушаалтнууд нь өөрийн болон бусдын хувийн ашиг сонирхлын төлөө KT&G группийн хөрөнгийг ашиглах боломжгүй бөгөөд ажил үүргээ биелүүлэхэд шаардлагатай хүрээнд шударгаар ашиглаж, удирдах хэрэгтэй.

Example

• Эд хөрөнгө хамгаалахын тулд хориглох үйлдэл

- Компанийн эд хөрөнгийг гэмтээх, завших, хулгайлах, зөвшөөрөлгүй ашиглах, зөвшөөрөлгүй түрээслэх, зөвшөөрөлгүй худалдахыг хориглоно.
- Зардлын захиран зарцуулах стандартыг зөрчсөн эсвэл худал мэдээлэл агуулсан зардлыг тооцох болон компанийн картыг ашиглахыг хориглоно.
- Утас, интернэт, PC, сервер, ажлын систем зэрэг компанийн мэдээллийн технологийн хөрөнгө болон төхөөрөмжийг хувиараа ашиглахыг хориглоно.

2.2 Мэдээлэл хамгаалах

KT&G групп нь компанийн бүх мэдээллийг чандлан хянаж, хамгаалах бөгөөд өрсөлдөгч төдийгүй гуравдагч этгээдийн худалдааны нууц, оюуны өмчийн эрхийг шударга бусаар олж авах болон ашиглахгүй.

2.2.1 Худалдааны нууц болон оюуны өмчийн эрхийг хамгаалах

KT&G группийн ажилтан, албан тушаалтнууд холбогдох хууль тогтоомж, компанийн дүрэм журмын дагуу эд хөрөнгөний үнэ цэнтэй компанийн бүх мэдээллийг хамгаалах ёстой.

Хамгаалагдсан компанийн мэдээлэлд санхүүгийн мэдээлэл, судалгаа хөгжүүлэлт, патент, барааны тэмдэг, ашигтай загварын эрх, дизайны эрх, зохиогчийн эрх зэрэг оюуны өмчийн эрх, бүтээгдэхүүний мэдээлэл, бизнесийн стратеги болон төлөвлөгөө, үнийн бодлого болон маркетингийн стратеги, компани нэгдэх болон худалдан авах мэдээлэл, бусад захиргааны мэдээллүүд багтдаг бөгөөд үүгээр хязгаарлагдахгүй.

2.2.2 Гуравдагч этгээдийн худалдааны нууц болон оюуны өмчийн эрхийг хамгаалах

KT&G группийн ажилтан, албан тушаалтнууд оюуны өмчийн эрхийн талаарх холбогдох хууль тогтоомжийг дагаж мөрдөж, зөвхөн зөвшөөрөл олгосон тохиолдолд гуравдагч этгээдийн оюуны өмчийн эрхийг ашиглах боломжтой.

Мөн KT&G группийн ажилтан, албан тушаалтнууд утас нууцаар чагнах, хакердах, мөнгө өгөх зэрэг ёс зүйгүй арга хэрэгслээр дамжуулан өрсөлдөгч төдийгүй гуравдагч этгээдийн худалдааны нууц, оюуны өмчийн эрхийг олж авахгүй. Мөн гэрээний дагуу гуравдагч этгээдийн худалдааны нууцыг олж авахдаа тухайн үйлчилгээ үзүүлэгч хууль ёсны эрх мэдэлтэй эсэхийг баталгаажуулах хэрэгтэй бөгөөд нууц чанд сахих гэрээ байгуулсан тохиолдолд авч буй мэдээллийг гэрээний дагуу ашиглана.

Example**· Худалдааны нууц болон оюуны өмчийн эрхийг хамгаалах бодит жишээ**

- Шинэ бүтээгдэхүүний үзүүлэлт зэрэг зөвшөөрөлгүй компанийн мэдээллийг задруулахыг хориглоно.
- Зөвшөөрөлгүйгээр оффист автомат төхөөрөмж оруулах болон гаргах, программ суурилуулахыг хориглоно.
- Олон нийтийн газарт нууц мэдээллийг ашиглаж ажил хийх болон нууц мэдээлэл агуулагдсан ажлын материалыг бодлоггүйгээр орхихыг хориглоно.
- Өмнө ажиллаж байсан газрын нууц мэдээллийг задруулах болон ашиглахыг хориглоно.
- Лицензгүй программ зөвшөөрөлгүй ашиглахыг хориглоно.

дээлэл цуглуулах болон ашиглах ажлыг гуравдагч этгээдэд хүсэлт гаргах тохиолдолд гуравдагч этгээд холбогдох хууль тогтоомжийг дагаж мөрдөхийг шаарддаг.

※ “Хувийн мэдээлэл” гэдэг нь амьд хүний тухай мэдээлэл буюу нэр, иргэний үнэмлэхийн дугаар зэрэг тухайн хувь хүнийг мэдэж болох мэдээлэл бөгөөд ялгах тоо, хаяг байршлын мэдээлэл, онлайн таних тэмдэг зэрэг бусад мэдээлэлтэй хялбархан нэгтгэж болох хувь хүнтэй холбоотой мэдээлэл юм. Дээр дурдсанчлан нэр нууцалсан мэдээлэл ч мөн багтдаг.

2.3 Хувийн мэдээлэл хамгаалах

KT&G групп нь улс орон бүрийн хувийн мэдээллийг хамгаалах хууль тогтоомж болон KT&G группийн бодлогын дагуу бизнесийн зүй зохистой үйл ажиллагаа явуулах зорилгоор мэдээллийн эх үүсвэрийн зөвшөөрөл авах зэрэг хууль ёсны дагуу хувийн мэдээллийг цуглуулж ашигладаг бөгөөд хувийн мэдээлэл хууль бусаар алдагдахаас урьдчилан сэргийлж хамгаалахын төлөө хичээн ажилладаг. Мөн хувийн мэдээлэл

3 Компанийн тайлан, бүртгэл

3.1 Бүртгэлийг үнэн зөв хөтлөх, нягтлан бодох бүртгэлийн стандартыг дагаж мөрдөх

KT&G групп нь бизнестэй холбоотой гүйлгээний дэлгэрэнгүй мэдээллийг ил тод, үнэн зөв бүртгэж, хадгалж, нягтлан бодох бүртгэлийн бүх мэдээллийг нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмын дагуу бэлтгэдэг.

KT&G групп нь хуурамчаар үйлдэх, гээгдүүлэх, дураараа өөрчлөх замаар гүйлгээний агуулгыг гажуудуулж, хуурамч, хууль бус гүйлгээг хийхгүй бөгөөд компанийн бүх нягтлан бодох бүртгэлийг нягтлан бодох бүртгэлийн зарчмын дагуу гүйлгээний агуулгатай нийцэж байхаар бүртгэж тайлагнана.

3.2 Ил тод болгох зарчмыг дагаж мөрдөх

KT&G групп нь холбогдох хууль тогтоомж, биржийн журмын дагуу хувьцаа эзэмшигч болон оролцогч талуудын шийдвэрт чухал нөлөө үзүүлж болох эсвэл чухал ач холбогдолтой асуудлуудыг ил тод болгоно.

KT&G групп нь хувьцаа эзэмшигч болон оролцогч талуудад ил тод болгох мэдээллийг хялбар олж авах боломжтой аргаар, үнэн зөв мэдээллийг цаг тухайд нь шударгаар мэдээлэх бөгөөд зөвхөн зарим оролцогч талуудад хэсэгхэн агуулгыг ялгаварлаж дамжуулахгүй.

3.3 Баримт бичиг хадгалах

КТ&G групп нь холбогдох хууль тогтоомж, компанийн дүрэм журмын дагуу компаниас хянах баримт бичиг(цахим бичиг баримт багтсан)-г заасан байршил, хадгалах ёстой хугацааны турш хадгалах бөгөөд, хадгалах хугацаа өнгөрсөн баримт бичгийг худалдааны нууц алдагдах эрсдэлийг багасгахын тулд зарга үүсгэсэн материал зэрэг хадгалах онц шаардлагагүй тохиолдолд устгах хэрэгтэй.

ДЭВШИЛТЭТ

компани

4 Дотоодын болон олон улсын худалдаа

- 4.1 Шударга худалдаа
- 4.2 Нийлүүлэлтийн сүлжээний бодлого
- 4.3 Олон улсын худалдааны дүрэм журмыг дагаж мөрдөх
- 4.4 Мөнгө угаах, татвараас зайлсхийхээс урьдчилан сэргийлэх

5 Борлуулалт ба маркетинг

- 5.1 Хариуцлагатай борлуулалт болон маркетингийн үйл ажиллагаа
- 5.2 Ил тод байдал
- 5.3 Дүрэм журмыг дагаж мөрдөх

6 Судалгааны ёс зүй

- 6.1 Хариуцлагатай судалгаа хөгжүүлэлтийн үйл ажиллагаа
- 6.2 Судалгааны бүрэн бүтэн байдал
- 6.3 Амьтан хамгаалах



4

Дотоодын болон олон улсын худалдаа

4.1 Шударга худалдаа

4.1.1 Шударга өрсөлдөөн

KT&G групп нь шударга худалдаатай холбоотой хууль тогтоомжийг дагаж мөрдөж, өрсөлдөгчидтэй чөлөөт өрсөлдөөн, харилцагч нартайгаа шударга худалдаа хийх замаар дэлхийн өнцөг булан бүрт байгаа хэрэглэгчдэд хамгийн чанартай бүтээгдэхүүнийг өрсөлдөхүйц үнээр нийлүүлэхийг эрмэлздэг.

4.1.2 Өрсөлдөгч нартай харилцах харилцаа

KT&G группийн ажилтан, албан тушаалтнууд шударга худалдааны талаарх хууль тогтоомжийг зөрчих, өрсөлдөөнийг хязгаарласан үйлдэл гэж буруугаар ойлгож болзошгүй өрсөлдөгч нартай харилцахаас зайлсхийх хэрэгтэй. Ажлын улмаас өрсөлдөгчтэй харилцах шаардлага гарсан бол үргэлж анхаарал болгоомжтой байж, хуулийн дагуух

үйлдэл мөн эсэхэд эргэлзэж байвал заавал компанийнхаа хуулийн хэлтэст хандаж тусламж авах хэрэгтэй.

Ажилтан, албан тушаалтан нь өрсөлдөгчтэй холбоо тогтоохдоо дараах зүйлсийг үргэлж санаж байх ёстой.

- Хуулиар тодорхой зөвшөөрснөөс бусад тохиолдолд худалдааны нөхцөл, бүтээгдэхүүний үнэ, үйлдвэрлэлийн хэмжээ гэх мэт нарийн мэдээллийг хэлэлцэж болох албан болон албан бус уулзалтад бүү оролц.
- Хэрэв таны оролцсон хурал тохиролцооны шинжтэй мэт санагдвал эсэргүүцэж байгаагаа тодорхой илэрхийлж, хурлын тэмдэглэлд бичиж үлдээн нэн даруй хурлыг орхино уу. Мөн энэхүү нөхцөл байдлын талаар хуулийн хэлтэст аль болох хурдан мэдэгдэнэ.

- Өрсөлдөгчийн талаарх мэдээллийг хуулийн дагуух арга, журмаар олж авсан ч гэсэн тухайн мэдээллийн эх үүсвэр, арга замыг тодорхой тэмдэглэн бичиж хадгална.

4.2 Нийлүүлэлтийн сүлжээний бодлого

KT&G групп нь бизнесийн түншүүдээ сонгохдоо чанар, өртөг, хүргэлт, найдвартай байдал, туршлага, ёс зүй, аюулгүй байдал, байгаль орчин, хүний эрх зэрэг хүчин зүйлсийг цогцоор нь үнэлж сонгохыг эрмэлздэг.

KT&G групп нь нийлүүлэлтийн сүлжээний тогтвортой байдлыг хангах нь урт хугацааны өсөлтийг бий болгодог гэдэгт итгэдэг юм. Иймээс бизнесийн түнш нь холбогдох хууль тогтоомжийг дагаж мөрдөн бизнесийн үйл ажиллагааг явуулахыг шаардаж нийгэм, байгаль орчин, ёс зүйн хувьд хариуцлагатай байхыг зөвлөдөг.

Худалдан авалтын удирдлага, бизнесийн түншүүдтэй харилцах харилцааг хариуцдаг KT&G группийн ажилтан, албан тушаалтнууд гэрээ байгуулсан бизнесийн түншүүд холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн тохиолдолд KT&G групп хариуцлага хүлээнэ гэдгийг санаж байх хэрэгтэй. Бизнесийн

түншүүд үүргээ биелүүлэхэд байнгын хяналт тавьж, KT&G группийн стандартад нийцэхгүй ямар нэгэн үйлдлийг олж илрүүлсэн тохиолдолд нэн даруй яаралтай арга хэмжээ авахыг хүсэж байна.

Example

• Бизнесийн түншүүдэд тавих хяналтын жагсаалт

- Бизнесийн түнш нь ажилчдын эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангаж, албадан хөдөлмөр эрхлэхийг хориглох заалтыг дагаж мөрдөж байгаа эсэхийг шалгах
- Бизнесийн түнш бизнес эрхлэхдээ байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг харгалзан үзэж, экосистемийг хамгаалах хүчин чармайлт гаргаж байгаа эсэхийг үнэлэх
- Бизнесийн түнш нь авлига, хил дамнасан хууль бус наймаа болох хууль бус худалдаа, татвараас зайлсхийх, мөнгө угаах зэрэг хууль бус үйл ажиллагаанд оролцож байгаа эсэхийг шалгах

4.3 Олон улсын худалдааны дүрэм журмыг дагаж мөрдөх

KT&G групп нь улс орон, олон улсын байгууллагаас хэрэгжүүлж буй импорт, экспортын хяналт, худалдааны хязгаарлалт, хориг зэрэг хууль эрх зүйн болон эдийн засгийн хориг арга хэмжээг тасралтгүй хянаж, холбогдох дүрэм журмыг дагаж мөрдөнө. Олон улсын худалдааны дүрэм журмыг дагаж мөрдөхтэй холбоотой анхаарах гол зүйлсийг доор хэсэгт жагсаав.

- Дайны эд материалыг хууль бусаар экспортлох, үндэсний томоохон нууцыг зөвшөөрөлгүй этгээдэд задруулахыг хориглоно.
- Импорт, экспортын гаалийн бүрдүүлэлтийн бичиг баримтыг үнэн зөв бөглөх(гарал үүслийг бичих, барааг ангилах, тохирох гаалийн мэдүүлгийн үнийг бичих зэрэг).
- Тодорхой улстай худалдаа хийх болон тодорхой улс орнуудад бизнес эрхлэхийг хориглосон худалдааны хориг, эдийн засгийн хориг арга хэмжээг дагаж мөрдөнө.

- Экспортын тусгай зөвшөөрөл шаардлагатай эсэхийг урьдчилан шалгаж, шаардлагатай бол зөвшөөрөл авах үйл явцыг үргэлжлүүлнэ.
- Үндсэн үнээс бага үнэтэй, төрөөс зохих бус татаас ашиглах зэрэг хууль бус экспортын үйлдлийг хориглоно.

4.4 Мөнгө угаах, татвараас зайлсхийхээс урьдчилан сэргийлэх

KT&G групп нь улс орон бүрийн мөнгө угаах, татвараас зайлсхийхийн эсрэг хууль тогтоомжийг дагаж мөрддөг бөгөөд мөнгө угаах, татвараас зайлсхийх, терроризм зэрэг хууль бус үйл ажиллагаа дэмжихэд оролцохгүй.

CEO
мэндчилгээ

Ёс зүйн дүрмийн
танилцуулга

1
Ажлын ёс зүй

2
Хөрөнгө, мэдээллийн
хамгаалалт

3
Компанийн баримт
бичиг, бүртгэл

4
**Дотоодын болон олон
улсын худалдаа**

5
Борлуулалт ба
маркетинг

6
Судалгааны ёс зүй

7
Нийгмийн өмнө
хүлээсэн үүрэг

8
Хүний эрхийн удирдах
зарчим

Example

• **Хууль бус үйлдэл гэж үзэх магадлалтай худалдаа**

- Тайлагнах ёстой үүрэг хариуцлагаас зугтах зорилгоор тодорхой үнийн дүнгээс бага үнийн дүнгээр олон удаа давтан гүйлгээ хийсэн худалдаа
- Энгийн бус эмх цэгцгүй худалдаа
- Татвараас зугтах, мөнгө угаах газар хэмээн нэрлэгдсэн бүс нутагтай холбоотой худалдаа
- Энгийн бус дансаар борлуулалтын төлбөрийг төлсөн худалдаа
- Худалдаатай холбоогүй гуравдагч этгээдэд төлбөр төлсөн болон төлбөр авсан тохиолдол

5

Борлуулалт ба маркетинг

5.1 Хариуцлагатай борлуулалт болон маркетингийн үйл ажиллагаа

KT&G групп нь тус группээс нийлүүлж буй бүх бүтээгдэхүүнийг хэрэглэгчдэд зөвөөр танилцуулахыг хичээдэг бөгөөд хууль бус худалдаа болон маркетингийн үйл ажиллагаа явуулдаггүй.

KT&G групп нь холбогдох хууль тогтоомж, компанийн маркетингийн бодлогыг зөрчихөөс урьдчилан сэргийлж хуулийн хэлтэст урьдчилан шалгуулсны дараа хэрэгжүүлж, ажилтан, албан тушаалтнуудыг сургаж, холбогдох үйл ажиллагааны талаар хяналт шалгалт хийх замаар дотоодын хуулийн хөтөлбөрийг бий болгож хэрэгжүүлдэг.

5.2 Ил тод байдал

KT&G групп нь хэрэглэгчдэд худал, гүтгэлгийн шинж чанартай сурталчилгаа явуулдаггүй. Мөн бид чухал баримтуудыг нуухгүйгээр бүтээгдэхүүний талаарх мэдээллийг ил тод, үнэн зөв хүргэхийг хичээдэг ба бүх зар сурталчилгаа, сав баглаа боодолдоо холбогдох хууль тогтоомжийг дагаж мөрддөг.

KT&G групп нь хэрэглэгчдэд итгэлийг бий болгохын тулд маркетингийн худал хуурмаг хэллэгийг ашигладаггүй бөгөөд янз бүрийн сувгаар дамжуулан үйлчлүүлэгчийн дуу хоолойг сонсдог.

5.3 Дүрэм журмыг дагаж мөрдөх

KT&G групп нь бүтээгдэхүүний борлуулалт, маркетингтай холбоотой улс орон бүрийн хууль тогтоомжийг дагаж мөрддөг. KT&G ажилтан, албан тушаалтнууд борлуулалт, маркетингийн бодлогыг бий болгох, өөрчлөхдөө хууль тогтоомжийг зөрчихгүйн тулд маш анхаарал болгоомжтой байх хэрэгтэй бөгөөд хэрэв тухайн бодлого нь хууль зөрчсөн гэж сэжиглэж байвал хуулийн хэлтэстэй заавал зөвлөлдөж тохирох аргыг хайж олох ёстой.

Example

• Борлуулалт, маркетингийн үйл ажиллагаанд хориглох зүйлс

- Тамхины хувьд насанд хүрээгүй хүүхдэд чиглэсэн борлуулалт, маркетингийн үйл ажиллагаа явуулахыг хориглоно.
- Эрүүл мэндэд тустай эм бэлдмэл, эм, гоо сайхны бүтээгдэхүүн зэргийн үр дүнгийн талаарх худал, хэтрүүлсэн сурталчилгаа хийхийг хориглоно.
- Буцаан олголт зэрэг хууль бус худалдааны арга ашиглахыг хориглоно.

6 Судалгааны ёс зүй

6.1 Хариуцлагатай судалгаа хөгжүүлэлтийн үйл ажиллагаа

КТ&G групп нь холбогдох хууль тогтоомж, үндэсний бодлогын дагуу судалгаа хийдэг. Мөн шаардлагатай зохицуулалтын байгууллагын шаардлагыг хангахын тулд өргөн хүрээний сэдвээр мэргэшсэн мэргэжилтнүүдийг ашигладаг. КТ&G групп нь бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн талаар дараах хүчин чармайлтыг гаргаж байна.

- Судалгааны мөн чанар, зорилгын талаар бүх оролцогчдод мэдэгдэнэ.
- Судалгааны явцад олж авсан бүх мэдээллийг хууль ёсны дагуу хадгалж, удирдана.
- Шинэ бүтээгдэхүүний зохицуулалтын зөвшөөрөл авахын тулд боловсронгуй, найдвартай мэдээлэл бэлтгэнэ.

6.2 Судалгааны бүрэн бүтэн байдал

КТ&G групп нь тогтвортой судалгаа хөгжүүлэлтээр дамжуулан олсон мэдээллийн бүрэн бүтэн байдал, чанарыг хадгалахад анхаардаг.

КТ&G групп нь оролцогч талууд шинжлэх ухааны судалгааны үр дүнтэй холбоотой мэдээлэлд үндэслэн чухал шийдвэр гаргадаг гэдэгт анхааран, үнэн зөв, бодитой мэдээлэл хүргэхийн төлөө хичээдэг.

6.3 Амьтан хамгаалах

KT&G групп нь амьтны туршилтыг орлох аргуудыг нэн тэргүүнд тавьдаг бөгөөд амьтанд туршилт хийхдээ хүн төрөлхтний нийгмийн сайн сайхан, амьтны амь насыг хүндэтгэн дээдлэхэд анхааран ажилладаг. Энэ тохиолдолд KT&G групп нь холбогдох хууль тогтоомжид заасан хэмжээнээс давсан түвшинд амьтны амь насыг хамгаалах, аюулгүй байдлыг хангах, нийгмийн сайн сайхныг дэмжих зэрэг хичээл зүтгэл гарган анхаарч ажилладаг.

Хүртээмжтэй компани

7 Нийгмийн өмнө хүлээсэн үүрэг

- 7.1 Байгаль орчныг хамгаалах
- 7.2 Нийгмийн хувь нэмэр
- 7.3 Үйлчлүүлэгчдэд төвлөрсөн байдал
- 7.4 Хувьцаа эзэмшигчдийг хүндэтгэх

8 Хүний эрхийн удирдах зарчим

- 8.1 Хүний эрхийг хамгаалах бодлогыг дагаж мөрдөх
- 8.2 Ажлын байрны дарамт, бэлгийн дарамт үзүүлэхийг хориглох
- 8.3 Ялгаварлан гадуурхахыг хориглох болон ялгаатай байдлыг хүндэтгэх
- 8.4 Аюулгүй ажлын орчныг бүрдүүлэх
- 8.5 Хөдөлмөрийн суурь эрхийг хангах



7

Нийгмийн өмнө хүлээсэн үүрэг

7.1 Байгаль орчныг хамгаалах

KT&G групп нь бохирдуулагч бодисын ялгаралтыг багасгах, байгаль орчны ослоос урьдчилан сэргийлэхийн тулд холбогдох хууль тогтоомжийг дагаж мөрддөг. Цаашлаад байгаль орчныг хамгаалах идэвхтэй үйл ажиллагаануудаар дамжуулан байгаль орчны асуудлыг сайжруулах, уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг хариу арга хэмжээ авах, хүлэмжийн хий, хог хаягдлын менежмент, бүтээгдэхүүний байгальд ээлтэй байх зэрэгт тасралтгүй анхааран оролцож, илүү өндөр түвшинд байгаль орчны удирдлагын тогтолцоог бий болгож, тухайн орон нутгийн байгаль орчныг хамгаалах үүрэг хариуцлагаа биелүүлж байна.

KT&G группийн байгаль орчныг хамгаалах хүчин чармайлт нь үйлдвэрлэл, бизнесийн байгууллагаас эхлээд логистик, түгээлтийн бүх үе шат, түүнчлэн бүтээгдэхүүн, үйлчилгээний нөлөөллийг бүхэлд нь хамардаг. KT&G групп төдийгүй бизне-

сийн түнш ч мөн адил байгаль орчныг хамгаалах үйл ажиллагаанд хамтрахын тулд маш их анхааран ажиллаж байна.

7.2 Нийгмийн хувь нэмэр

KT&G группийн менежментийн үйл ажиллагаа нь нийгэмд суурилан явагддаг бөгөөд нийгэмтэй зохицон хөгжиж, тогтвортой байж чадна гэсэн итгэлд суурилан нийгэмд урт хугацааны эерэг өөрчлөлтийг авчрахын тулд төрөл бүрийн үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.

KT&G нь нийгэмд хүрэх тогтвортой хөгжлийн тогтолцоогоор дамжуулан тухайн орон нутагт тохирсон хөтөлбөрийг хэрэгжүүлж, тэтгэлэг, халамж, соёл, урлаг зэрэг төрөл бүрийн салбарт идэвхтэй дэмжлэг, туслалцаа үзүүлэн тухайн орон нутгийн нийгмийн нэгэн гишүүний хувьд үүрэг хариуцлагаа

ухамсарлан хэрэгжүүлж байгаа бөгөөд нийгмийн тогтвортой үнэ цэнийг бий болгоход тэргүүлэн ажиллаж байна.

7.3 Үйлчлүүлэгчдэд төвлөрсөн байдал

KT&G ажилтан, албан тушаалтнууд хэрэглэгчийн байр сууринаас харахад бодит тусламж болох, тэдний сэтгэлд нийцэхүйц үнэ цэнийг тасралтгүй бий болгож, хэрэглэгчдэд өгсөн амлалтаа биелүүлэхэд анхааран ажиллаж байна.

Үүний тулд KT&G групп нь хэрэглэгчийн санал бодлыг үргэлж сонсож, хэрэглэгчийн бүх шийдвэр болон үйлдлийг эхэнд тавьж байна. Мөн итгэлцэл дээр суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээгээр дамжуулан хэрэглэгчийн сэтгэл ханамжийг дээд зэргээр нэмэгдүүлж байна.

7.4 Хувьцаа эзэмшигчдийг хүндэтгэх

KT&G групп нь хувьцаа эзэмшигчийн хууль ёсны шаардлага, эрхээ хэрэгжүүлэх байдлыг хүндэтгэн авч үздэг. Мөн тогтвортой удирдлагын шинэчлэл, өсөлтийн стратегиар дамжуулан байгууллагын үнэ цэнийг нэмэгдүүлж, ил тод шийдвэр гаргалт, үр ашигтай удирдлагын үйл ажиллагаагаар дамжуулан хууль ёсны ашиг олох байдлыг хэрэгжүүлж хувьцаа эзэмшигчдийн үнэ цэнийг өсгөхийг зорьж байна.

8

Хүний эрхийн удирдах зарчим

8.1 Хүний эрхийг хамгаалах бодлогыг дагаж мөрдөх

KT&G групп нь глобал компанийн хувьд хөдөлмөртэй холбоотой хүний эрхийн асуудлыг шийдвэрлэхэд салбарын үүрэг, хариуцлагыг тодорхойлсон Хүний эрхийн түгээмэл тунхаглал(Universal Declaration of Human Rights), НҮБ-ын Бизнес ба хүний эрхийн үндсэн зарчмууд(UN Guiding Principles on Business and Human Rights), Олон улсын хөдөлмөрийн байгууллагын(International Labour Organization Conventions) 138, 182 дугаар конвенц зэрэг олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн зарчмыг дэмжин ажилладаг. Үүний үндсэн дээр KT&G групп нь дотоод, гадаад харилцаа холбоог дэмжих, эрхийг хамгаалах зэрэг хүний эрхийн удирдлагыг бэхжүүлэхэд анхааран ажиллаж байна.

KT&G групп нь ямар нэгэн шалтгаанаар хүчирхийлэл, айлган сүрдүүлэх, цагдан хорих зэргээр ажилчдын эрх чөлөөнд

халдсан албадлагын хөдөлмөр эрхлүүлэхгүй бөгөөд хүүхдийн хөдөлмөрийг чанд хатуу хориглодог. Мөн бизнесийн түншүүдийн албадан хөдөлмөр эрхлэх, хүүхдийн хөдөлмөр эрхлэх асуудлыг ч үл тэвчдэг бөгөөд идэвхтэй байдлаар хариу үйлдэл үзүүлдэг.

Цаашлаад хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, ажлын цаг, амралтын цаг зэрэгтэй холбогдох Олон улсын хөдөлмөрийн байгууллага(ILO)-н конвенц болон улс орон бүрийн хөдөлмөрийн стандартын хуулийг чанд сахин мөрддөг.

8.2 Ажлын байрны дарамт, бэлгийн дарамт үзүүлэхийг хориглох

KT&G групп нь хэл амаар доромжлох, хүчирхийлэл, бэлгийн дарамт зэрэг зүй бусаар хэл ам, харц болон биеийн дарамтаас ажилтан, албан тушаалтнуудыг хамгаалдаг. Шууд харааж

зүхэх, заналхийлэх, түүнчлэн сүрдүүлэх төдийгүй доромжилсон үг хэллэг, үйлдлийг хориглодог.

KT&G групп нь ажлын байран дахь дарамт, бэлгийн дарамттай холбоотой асуудлыг чөлөөтэй илэрхийлэх орчныг бүрдүүлэхийн төлөө хичээн ажиллаж байна. Ажлын байран дахь дарамт, бэлгийн дарамтыг мэдэгдэх эсвэл холбогдох мөрдөн байцаалтад мэдүүлэг өгсөн гэх шалтгаанаар хохирол амсах эсвэл өшөө авах үйлдэл гаргахыг чанд хатуу хориглоно.

Example

• Ажлын байран дахь дарамт, бэлгийн дарамтад хамаарах үйлдэл

- Ажлын байран дахь албан тушаал, харилцаа зэрэг байр суурийн давуу байдлаа ашиглан ажлын орчин дахь зүй зохистой хэмжээг хэтрүүлэн эсрэг талын хүндээ биеийн болон сэтгэл санааны дарамт учруулах, ажлын орчныг дордуулах үйлдэл
- Бусдын бодол санааг үл харгалзан биед нь хүрэх эсвэл биеийн аль нэг хэсгийг илэх зэрэг бэлгийн дарамт учруулж, жигшил төрүүлэх мөн шаардлага биелүүлээгүй гэсэн шалтгаанаар ажлын хохирол учруулах үйлдэл
- Бусдын бодол санааг үл харгалзан нүдээрээ харан мэдэж болохуйц үйлдлээр дамжуулан бэлгийн ичгүүртэй санагдуулах үйлдэл хийх

8.3 Ялгаварлан гадуурхахыг хориглох болон ялгаатай байдлыг хүндэтгэх

KT&G нь ялгаварлан гадуурхах байдлын эсрэг хууль тогтоомжийг даган мөрдөж, ажилтан, албан тушаалтан төдийгүй бизнесийн түншүүд зэрэг оролцогч талуудын ялгаатай байдлыг чухал үнэ цэнтэй хэмээн үзэж бодол санаа, байр суурь, итгэл үнэмшлийг нь хүндэтгэдэг орчныг бүрдүүлэхийн төлөө хичээн ажиллаж байна.

KT&G групп нь ажилд авах, тушаал дэвшүүлэх, хуваарилах, шагнах, сургалт төдийгүй ажилтай холбогдсон бүхий л нөхцөл байдалд хувь хүний онцлог, тэр дундаа хүйс, арьсны өнгө, үндэс угсаа, шашин шүтлэг, хөгжлийн бэрхшээл, нас, жирэмслэлт, цэргийн алба, нийгмийн байр суурь, улс төрийн үзэл бодол гэх мэт шалтгаанаар шударга бусаар ялгаварлан гадуурхахгүй.

8.4 Аюулгүй ажлын орчныг бүрдүүлэх

KT&G ажилтан, албан тушаалтан нь хөдөлмөрийн аюулгүй байдлын талаарх хууль тогтоомжийг чанд сахин мөрддөг. Үүгээр дамжуулан өөрийгөө болон хамт олон, бизнесийн түнш, хэрэглэгчийн төрөл бүрийн үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлж, буруу дадал зуршил, тогтолцоог идэвхтэй сайжруулснаар аюулгүй ажлын орчныг бүрдүүлнэ.

Example

• Аюулгүй ажлын орчныг бий болгох жишээ

- Улс орон бүрийн хөдөлмөрийн аюулгүй байдал зэрэг холбогдох хууль тогтоомж, байгууллагын дотоод зарчмыг дагаж мөрдөх
- Аюултай эд зүйлсийг зайлуулах, аюулгүй байдлын төхөөрөмж суурилуулах зэрэг ажлын байран дахь эрсдэлт хүчин зүйлсийг бууруулах
- Хангалттай хэмжээний хувийн хамгаалах хэрэгслийг бэлдэх, хэвийн ажиллаж байгаа эсэхийг тогтмол шалгаж байх

8.5 Хөдөлмөрийн суурь эрхийг хангах

KT&G групп нь ажилчдын эвлэлдэн нэгдэх эрх, хамтын гэрээ хэлэлцээр хийх эрх, хамтын үйл ажиллагаа явуулах эрх зэрэг хөдөлмөрийн үндсэн эрхийг баталгаажуулна. Үүгээр дамжуулан KT&G групп нь хөдөлмөрийн нөхцөлийг хадгалах, сайжруулах, ажилчдын эдийн засаг, нийгмийн байр суурийг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулна.

Example

• Хөдөлмөрийн үндсэн эрхийг баталгаажуулах жишээ

- Улс орон бүрийн хөдөлмөрийн тухай хууль тогтоомжийн дагуу эвлэлдэн нэгдэх эрх чөлөө, хэлэлцээр хийх эрхийг батлах
- Үйлдвэрчний эвлэлд нэгдэх зэрэг үйлдлээс үүдэн ялгаварлан харьцахыг хориглоно.
- Үйлдвэрчний эвлэл, ҮЭ-ийн гишүүдийн хөдөлмөрийн үндсэн эрхийн шударга, хууль ёсны дагуух үйлдлийг хэрэгжүүлэхэд саад учруулахыг хориглоно.